



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн гишүүдийг  
томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн гишүүдийг хавсралт ёсоор томилсугай.

2. Томилогдсон гишүүдэд Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн  
..84.. дүгээр тогтоолын хавсралт

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ” ОНӨААТҮГ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭЛДЭХҮҮНД ТОМИЛОХ ГИШҮҮДИЙН НЭРС**

№	Хуулийн этгээдийн нэр	Томилогдох гишүүний нэр	Эрхэлж буй албан тушаал
1	“Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ	Б.Мөнхцэцэг	Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч
2		Ч.Мэндбаяр	Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч
3		М.Халтар	Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
4		Л.Дэлгэр	Нийслэлийн ЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний газрын дарга
5		Б.Төгслхам	Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн ахлах мэргэжилтэн